



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/262

Хэрлэн сум

**Нисэх загварын тэмцээн зохион  
байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах заалтын хүрээнд Аймгийн аварга шалгаруулах цомын төлөөх нисэх загварын тэмцээн зохион байгуулахад 3,950,000 (гурван сая есөн зуун тавин мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ